

иргэд, гэр бүл, хөдөлмөрийн хамт олон, аж ахуйн нэгж, төрийн болон төрийн бус байгууллагуудын үүрэг, хариуцлагын тогтолцоог бий болгох, төлөвшүүлэх, урамшуулах эрх зүйн орчинг бүрдүүлэх.

г/ Ялтныг нийгэмшүүлэх хүрээнд хорих байгууллагаас иргэний нийгмийн, түүний дотор боловсрол, соёл урлаг, спорт, хэвлэл мэдээлэл, аж ахуйн нэгж, байгууллагатай явуулах ажиллагааг өргөжүүлэх, сурталчилах, төлөвлөлт, зохион байгуулалт, үр дүнд онцгойлон анхаарч урамшуулах эрх зүйн механизмыг бий болгох.

д/ Хорих ял эдлүүлэх болон ялтныг нийгэмшүүлэх ажиллагаанд хүн судлал, анагаах ухаан, сурган хүмүүжүүлэх ухаан, сэтгэл судлал, социологийн шинжлэх ухааны мэдлэг, ололтыг ашиглах ажиллагааг өргөжүүлэх, захиалгаар судалгааны ажлыг мэргэжлийн түвшинд хийлгэн, практикт үр дүнг нэвтрүүлэх явдлыг эрх зүйн орчин, зохион байгуулалтаар дэмжих зэрэг болно.



Ц.ОЧГЭРЭЛ

Хууль сахиулахын их сургуулийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэл судлал төвийн арга, хурандаа



Б.МӨНХБААТАР

Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн сургуулийн Нийгмийн ажлын тэнхимийн баш, ахлах дэслэгч

ЯЛТАН СЭТГЭЛ ЗҮЙН ХЯМРАЛД ОРОХ ШАЛТГААН НӨХЦӨЛ, ТҮҮНЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭН, ДАВАН ТУУЛАХ АРГА ЗАМ

Хорих ял эдлүүлэх байгууллагын хуулиар хүлээсэн чиг үүргээ биелүүлэх, ялын зорилгыг хангахад ялтан, хоригдогсдын зан төлөвийн өөрчлөлт, сэтгэл зүйн онцлог, харилцааг судалж улмаар нөлөөлөх явдал чухал юм.³³

"Бие хүн"³⁴-ий зан төлөвийн онцлог шинжийг урьдчилан тодорхойлохын тулд бие хүний иж бүрэн, суурь онцлог шинжүүдийг туршилт, задлан шинжлэлийн тусламжтайгаар судлах, дүн шинжилгээ хийн тухайн орчин нөхцлийн харилцан хамаарлыг судлах явдал байдаг.

³³ С.Жанцан "Хууль зүйн сэтгэл судлал" 2001 он. Улаанбаатар. 387 дах тал

³⁴ - Г.Оллпорт "Бие хүн гэдэг нь хүний амьдралын явцад төлөвшдөг физиологи сэтгэл зүйн хувийн өвөрмөц онцлог ба бие хүний шинжүүд бөгөөд тэдгээр нь тухайн хүний сэтгэхүй, зан үйлийн дахин давтагдашгүй байдын тогтолцоо юм".

Бие хүний онцлог шинж тэмдгүүдийг судлах орчин үеийн статистикийн хүчин зүйлүүдийн задлан шинжилгээний нарийн арга байдаг бөгөөд энэ нь үйл явцад бие хүний талаарх үнэлгээ, ажиглалт дүгнэлт, санал, асуулга, амьдралын үйл явц, орчин нөхцөлд хийсэн ажиглалтын дүнд олон янзын үзүүлэлтүүдийг байж болох хамгийн цөөн тоонд хүргэж, дүгнэх боломжтой хэлбэрт оруулах явдал юм. Энэхүү үйл явцын эцэст статистик талаас бие хүний шинж онцлогийг илэрхийлэгч, үл хамаарах хүчин зүйлүүдийг тодорхойлдог. Тус аргын тусламжтайгаар Раймонд Кеттел 1949 онд 16 хүчин зүйлт асуулгаа боловсруулсан бөгөөд энэ нь сэтгэл оношилгооны практикт өргөн хэрэглэгдсээр байна. Энэхүү асуулга нь олон талыг хамарсан, хүмүүсийн бодгаль хувийн ялгааны олон талын мэдээллийг тодорхойлж өгдөг бөгөөд товчилсон 105 асуулга бүхий судалгааг Монгол улсын хэмжээнд анх удаа гэмт хэрэг үйлдсэний улмаас шүүхээр шийтгэгдэн хорих анги, шийдвэр гүйцэтгэх албанд ял эдэлж буй нийт 2035 ялтан, хоригдогсдоос түүврийн аргаар авсан Р.Кеттелийн 16 хүчин зүйлт асуулгаар судалгаа авч боловсруулан³⁵ дүн шинжилгээ хийлээ.

Ялтан, хоригдогсдын бие хүний онцлог шинжийн илрэллээс үзэхэд сэтгэл зүйн тэнцвэрт бус байдлыг товч байдлаар авч үзэхэд сэтгэл зүйн хямрал, гутралд нөлөөлж буй нийгмийн зан үйл, хүмүүжил, зан суртахуун, боловсролын байдал,

ахуйн орчин нөхцөл гэж тодорхойлж болох юм. Тухайн орчин нөхцөл, янз бүрийн цочроол, нөлөөллөөс хамаарч тохиолдлын байдлаар олон янзаар хувирч өөрчлөгддөг бөгөөд энэхүү орчин нөхцлийг нөлөөллийн хэлбэрээс шалтгаалан хэд хэдэн бүлэгт хувааж авч үзлээ. Үүнд:

1. Нийгэм-эдийн засгийн орчин нөхцөл:

Энэхүү бүлэг хүчин зүйл нь улс орны нийгмийн амьдрал, ард түмний амьжиргааны түвшин, эдийн засгийн тогтвортой байдал, хөгжлийн чадавхи, улс орны гадаад харилцаа, нийгмийн үнэт зүйлсийг эрх зүйн үүднээс баталгаажуулсан байдал зэрэг олон хүчин зүйлсээр тодорхойлогддог цогц ойлголт юм.

Аливаа улсын нийгэм, эдийн засгийн хөгжил, түүний түвшин зэрэг нь нийгмийн сэтгэл зүйн уур амьсгалтай салшгүй холбоотой байдаг олон жишээ дурдаж болох юм. Нийгэм-эдийн засгийн байдал хэдий чинээ тогтворгүй, баталгаагүй байна төдий чинээ нийгмийн сэтгэл зүй тогтворгүй, эмзэг байхын зэрэгцээ аливаа сөрөг үр дагавар дагуулж байдаг.

Хорих ял эдэлж буй хүмүүс нь сэтгэл зүйн хувьд тогтворгүй байдалд байдгийн хувьд нийгэм-эдийн засгийн амьдралын аливаа өөрчлөлт, хөдөлгөөнийг маш эмзэг, сөргөөр хүлээж авдаг нь судалгааны ажиглалтаас харагдаж байна. Түүнээс гадна нийгмийн амьдралын баталгаагүй, тогтворгүй байдал нь ялтны хувьд гэр бүлийнхний амьдралын хүндрэл, үр хүүхдийн ирээдүйн баталгаатай байдалд ч эргэлзээтэй, үл итгэх байдал бий болгодог.

³⁵ ШШГЕГ-ын ТГГ-ын Нийгэм, сэтгэл зүйн хэлтсийн 2012.02.12-ны "БИЕ ХҮНИЙ ШИНЖИЙГ ТОДОРХОЙЛОХ" судалгааны үр дүнгийн боловсруулалтын тайлан.

2. Гэр бүлийн орчин нөхцөл:

Гэр бүлийн орчин нөхцөл буюу хүний өсч торних, төлөвших хамгийн ойрын хүрээлэл нь аливаа хүний сэтгэл зүйн болон амьдрах орчин, аливаад хандах хандлага зэргийг төлөвшүүлдэг өвөрмөц бичил орчин юм.

Хорих ангийн дотоод орчинд дасан зохицох, эсвэл тодорхой хугацааг дэглэмийн өвөрмөц нөхцөлд өнгөрүүлэхэд тухайн ялтны гэр бүлийн орчинд олж авсан сэтгэл зүйн хүмүүжил, биеэ авч явах чадвар нь хууль ёсны шаардлагыг сахин мөрдөх, бусад ялтан, хоригдогсодтой зөв харьцах зэрэгт голлох үүрэг гүйцэтгэдэг.

Түүнчлэн хоригдож буй хугацаанд гэр бүлийн зүгээс үзүүлж буй материаллаг болон сэтгэл зүйн тусламж нь тухайн ялтныг аливаа сэтгэл зүйн хямрал, өөрчлөлтөөс гарах, хүндрэлийг даван туулахад онцгой ач холбогдолтой байдаг.

Судалгаанаас үзвэл гэр бүлийн орчинд гарсан өөрчлөлт, тухайлбал: гэр бүл салалт, дотны хүнээс хагацах, гэр бүлийн амьжиргааны баталгаажих түвшинээс доогуур орлоготой байх зэрэг нь ялтны сэтгэл зүйн хувьд хямралд орох үндсэн шалтгаануудын нэг болж байдаг.

3. Хорих ял эдэлж буй орчин нөхцөл:

Шинээр буюу анх удаа хорих ял шийтгэгдсэн ялтны ихэнх нь хорих ангийн дотоод нөхцлийг буруугаар төсөөлөх, улмаар айж цочирдох явдал түгээмэл байдаг. Энэ нь хорих ангийн дотоод орчин нөхцлийн талаар буруу ойлголттой байдагтай холбоотой юм.

ШШГЕГ-ын харъяа хорих ангийн үйл ажиллагаа нь холбогдох

хууль эрх зүйн актаар зохицуулагдсан дотоод журам, дэглэм, цагийн хуваарийн дагуу зохион байгуулагддаг бөгөөд зарим ялтны хувьд энэхүү орчинд дасан зохицохгүй байх, улмаар сэтгэл зүйн хямралд орох явдал олонтоо тохиолддог.

Түүнчлэн хамт хоригдогсодтой харилцаанд ороход болон хорих ангийн онцлогоос шалтгаалан ажил, хөдөлмөрт хамрагдахад зарим ялтанд тодорхой сэтгэл зүйн хүндрэл өөрчлөлтүүд илэрдэг ба энэ бүхэн нь тухайн хүний хувийн зан чанар, сэтгэл зүйн онцлогтой шууд хамааралтай байдаг бөгөөд сэтгэл зүйн гүн хямрал, сэтгэцийн өөрчлөлтөнд орох магадлалтай байдаг.

Ялтны сэтгэл зүйн хямрал, гутралын шалтгаан:

Ялтны сэтгэл зүйн хямрал, гутралд орж буй шалтгааныг түүний эх сурвалж, үүсч бий болсон нөхцөл, онцлог шинжийг харгалзан дараах бүлэгт хувааж авч үзлээ. Үүнд:

1. Хувийн зан байдал, сэтгэл зүйн онцлогтой холбогдсон шалтгаан:

а) Төрөлхийн болон олдмол сэтгэл зүйн онцлог, өөрчлөлт.

Хэдийгээр эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны явцад болон шүүхийн шатанд хэрэг хариуцах чадвартай эсэх нь тогтоогдсон хэдий ч хорих ял эдлэх явцдаа илт сэтгэцийн өөрчлөлтөнд орох, урьдын элдэв эмгэг сэдрэх байдлаар ноцтой хор уршиг бүхий үйлдлийг ялтны зүгээс үйлдэх явдал практикт олонтоо тохиолддог. Иймд хорих ял эдлэх үед ялтны сэтгэцийн байдлыг нарийвчлан шалгах буюу нарийн мэргэжлийн эмнэлгийн шинжилгээ явуулах талаар

тодорхой зохицуулалт шаардлагатай болдог бөгөөд энэ талаар одоогоор нарийвчилсан зохицуулалт байхгүй байна.

Энд бид ялтны зүгээс өөрийн ял эдэлж буй нөхцлийг сайжруулах, эрүүгийн хариуцлагаас зайлсхийх гэх мэт зорилгоор санаатай худал өвчлөх, дүр эсгэх оролдлого тогтмол гардгийг тооцож үзэх шаардлагатай.

б) Тухайн хүний хувийн өвөрмөц зан байдал, онцлог. Тухайбал:

- өөртөө итгэлгүй, амьдралын тодорхой зорилгогүй байдал,

- өөрийгөө буруутгах, жигших үзэл бодол,

- гутранги үзэлд байнга автах,

- хэт айдаст автсан эсхүл байнгын уур цухалтай байх,

- ямар нэгэн зүйлд байнга санаа зовинох, түгшүүртэй байх,

Эдгээр хувийн зан байдлын онцлог нь сэтгэл зүйн хувьд хямралд орох шалтгаан болохоос гадна ялтны зүгээс өөр бусад ноцтой гэмт хэрэг, зөрчил үйлдэхэд ч зайлшгүй нөлөөлдөг гэдгийг тэмдэглэх нь зүйтэй.

в) Дасан зохицох чадваргүй байдал.

Энэ нь тухайн ялтан бие даан тодорхой харилцаанд оролцох чадваргүй байдлаасаа хамаарч орчны өөрчлөлтийг хүлээн авч түүнд дасан зохицохгүй байдлаар илэрхийн зэрэгцээ сэтгэл зүйн гүнзгий хямралд хүргэх нэг шалтгаан болдог. Тухайлбал хорих ангийн онцлог, дотоод зохион байгуулалт, дотоод журам, түүнчлэн хамт хоригдогсдын харьцаа, хандлага зэргийг өөртөө хүлээн авахад үүсдэг.

г) Согтуурах, мансуурах дон /хамаарал/.

Согтуурах, мансуурах дон, сэтгэл зүйн ачаалал, түүнээс үүдсэн дарамттай байх нь зарим тохиолдолд амиа хорлох, санаа бодол төрөхөд онцгой нөлөөлдөг.

д) Өөрийн үйлдсэн хэргээс жигших, түүндээ гутрах,

Дээрхи шалтгаан буюу аливаа сэтгэл зүйн болон хувийн онцлог зан байдлууд нь сэтгэлзүйн хямралд орох шалтгаан болохын зэрэгцээ ихэнхи тохиолдолд бусад шалтгаан нөхцөлтэй хавсран сэтгэл зүйн тэнцвэрт байдлаа алдах эх үүсвэр болдог.

2. Гэр бүлийн харилцаатай холбогдсон шалтгаан.

Ялтны гэр бүлийн харилцаатай холбогдсон шалтгаан нь цөөнгүй тохиолдолд нийгмээс тусгаарлагдан хуулийн дагуу тодорхой хязгаарлалтанд байгаа ялтны сэтгэл санааны өөрчлөлтөнд нөлөөлөх томоохон шалтгаан болдог. Үүнд:

а) Гэр бүлийн гишүүдийн амьдралын таагүй нөхцөл. Өөрөөр хэлбэл ямар нэг орлогогүй, амьжиргааны эх үүсвэргүй, ядуу зүдүү амьдрал, тодорхой орон байргүй байдал нь ялтанд сэтгэл зүйн маш их дарамт болохын хажуугаар үүнд өөрийгөө буруутгаж, сэтгэл санааны хямралд оруулдаг.

б) Гэр бүлийн гишүүн буюу дотны хүн нас барах (эсхүл хүнд өвчлөх). Хорих ял эдэлж байх үед гэр бүлийн гишүүн буюу хамгийн их хайрлаж, хүндэлж явсан хүний нас баралт нь сэтгэл санаанд хүчтэй нөлөөлөх шалтгааны нэг юм.

в) Гэр бүлийн зөрчил. Үүнд гэр бүл салалт, гэр бүлийн гишүүдтэй

маргах, үл ойлголцох, үл итгэх байдал зэргийг оруулан ойлгож болно.

г) Гэр бүлийн харилцаатай холбогдсон бусад гэнэтийн өөрчлөлтүүд,

3. Орчны өөрчлөлт буюу гаднах орчны нөлөөлөл.

а) Хорих ангийн дотоод зохион байгуулалт.

Шүүхийн шийтгэх тогтоолоор заагдсан төрөл дэглэмийн онцлог орчинд ч аливаа ялтны дасан зохицоход тодорхой бэршээлүүд гардаг. Түүнчлэн хорих ангийн байршлийн онцлог, үйлдвэрлэлийн чиглэл, хөдөлмөрлөх үйл ажиллагаанд хамрагдаж байгаа ялтныг энэхүү онцлогт дасан зохицоход ч зайлшгүй анхаарах шаардлагатай.

б) Ялтны дунд нэр хүндгүй болох, ичгүүртэй байдалд орох. Энэхүү шалтгаан нь дараах байдлаар илэрдэг. Үүнд:

- *Үйлдсэн хэргийн улмаас нэр хүндгүй болох, гадуурхагдах.* Тухайлбал: Хүчингийн гэмт хэрэг үйлдсэн, тэр тусмаа бага насны хүүхэд хүчирхийлсэн этгээд нь ялтан хоригдогсдын дунд нэр хүндгүй байхын зэрэгцээ илт гадуурхах хандлага байдаг.

- *Ижил хүйстэн байх.* бэлгийн чиг хандлага. Манай өнөөгийн нийгэмд үндэсний сэтгэл зүйн онцлогоос шалтгаалан бэлгийн чиг хандлагыг нийгмийн аль ч давхаргад хүлээж авдаггүйн зэрэгцээ жигших, гадуурхах явдал байдаг.

в) Хамт ял эдлэгсдийн зүгээс үзүүлж буй дарамт шахалт:

Энэ нь ялангуяа удаа дараа ял эдэлж байсан хоригдогсдоос байнгын шинжтэй үйлдэгддэг.

г) Албаны болон албан хаагчийн хууль бус шаардлага.

Зарим тохиолдолд албан хаагчийн зүй бус харьцаа, бусад үйлдлийн улмаас ялтан сэтгэл зүйн хувьд хямрах явдал байдаг.

Гэхдээ энд албан хаагчийг зориуд хууль зүйн хариуцлагад холбогдуулах, ямар нэг байдлаар хохирол учруулах зорилгоор хуурамчаар тухайн албан хаагчийг өөрийн үйлдлийн буруутан болгох санаа агуулсан үйлдэл цөөн бус үйлдэгдэж байсныг тооцон үзэх шаардлагатай.

4.Хууль зүйн харивцлагаас эмээх буюу зайлсхийх.

5.Хууль хяналтын байгууллагын алдаатай шийдвэрээс хамаарч сэтгэл зүйн хямралд орох явдал байдаг.

6. Бие эрхтний гажиг.

Тухайлбал:

-ярианы буюу хэлний /гажиг/ хөгжил дутуу байх

-гадна бие эрхтэн, дүр төрхний согог зэрэг нь тухайн хоригдогчийн бусдын өмнө ичгүүртэй эсхүл өөрийн энэ байдалд гоморхсон, хорссон сэтгэгдэл төрүүлдэг ба энэ нь тэдэнд дутуу дулимагийн мэдрэмжийг нэмэгдүүлж сэтгэл гутралд орох байдлыг бий болгож болзошгүй байдаг.

Дээрхи бүгдээс дүгнэн үзвэл хорих анги дахь хоригдогсдын сэтгэл зүйн хямрал, гутрал зэрэг сөрөг өөрчлөлтүүдийг тодорхойлон, шалтгаан нөхцлийг зөв тогтоон тэдэнд сэтгэл зүйн хувьд нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлэх нь ялтныг нийгэмшүүлэх цогц арга хэмжээний хүрээнд хийгдэх гол ажил юм.

Иймд хорих ангид ялтанд үзүүлэх сэтгэл зүйн нөхөн сэргээх